



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/207

Мандалговь

“Сителеком” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн төвийн хяналтын камерын нэгдсэн системийн зураг, төсөв боловсруулах ” зөвлөх үйлчилгээний ажлыг 30,000,000 (гучин сая) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналаар “Сителеком” ХХК-тай 30,000,000 (гучин сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зургийн даалгаврын дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Сителеком” ХХК-ийн захирал (Д.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



4822150515